

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/074/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 268512 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn Аудитор: Г.Ганбилэг Утас: 261628 Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн Утас: 99092231 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Г.ЧИНЗОРИГ
ТАНАА

2025.03.17 № 07/1074
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нийт орлогыг 11,050.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 10,974.3 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,036.5 сая төгрөгөөр, 75.9 сая төгрөгийн ашигтай ажиллагааар төлөвлөж, гүйцэтгэлээр 13,039.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 11,545.9 сая төгрөгийн зардал гарган, 1,494.0 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А-1/1689 албан бичгээр 7 тээврийн хэрэгсэл худалдан авахыг зөвшөөрсний дагуу тус баазад 1,980.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 5 тээврийн хэрэгслийн худалдан авалтыг хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	683,981,831.23	1,806,837,068.45
1.1.2	Дансны авлага	326,521,614.27	194,823,554.75
1.1.4	Бусад авлага	21,321,616.98	7,821,616.98
1.1.6	Бараа материал	78,342,876.18	75,767,729.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	16,106,610.56	10,507,307.79
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,126,274,549.22	2,095,757,277.86
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,640,348,482.24	13,519,719,544.98
1.2.2	Биет бус хөрөнгө	726,986,000.00	725,983,222.28
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,367,334,482.24	14,245,702,767.26
1.3	Нийт хөрөнгийн дүн	14,493,609,031.46	16,341,460,045.12
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	48,306,920.33	265,227,373.16
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	60,811,262.00	237,293,738.54
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	16,681,166.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	109,118,182.33	509,202,277.70
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	109,118,182.33	509,202,277.70
2.3	ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.3.1	Өмч	11,744,520,814.45	11,744,520,814.45
2.3.2	-төрийн	11,744,520,814.45	11,744,520,814.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,112,044,177.04	2,122,044,177.04
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	718,836,000.00	718,836,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(190,910,142.36)	1,236,856,775.93
2.3.11	Эздийн өмчийн дүн	14,384,490,849.13	15,822,257,767.42
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	14,493,609,031.46	16,341,460,045.12

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,670,064,517.75	11,801,710,619.77
2	Борлуулалтын өртөг	7,053,530,481.24	10,714,931,390.44
3	Нийт ашиг (алдагдал)	(2,383,465,963.49)	1,086,779,229.33
4	Түрээсийн орлого	506,118,000.00	445,802,499.98
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	1,544,947,823.49	792,403,495.67
9	Борлуулалт, маркетингийн зардал	72,831,409.08	613,636.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	405,757,103.64	505,317,100.31
11	Санхүүгийн зардал	1,228,115.19	805,182.81
12	Бусад зардал	256,943,199.67	211,273,030.02
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(711,907,527.15)	(112,966,509.39)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,781,067,494.73)	1,494,009,766.09
19	Орлогын татварын зардал	0.00	66,242,847.80
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	(1,781,067,494.73)	1,427,766,918.29
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,781,067,494.73)	1,427,766,918.29
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	1,534,657,352.37	16,130,205,843.86
1	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	55,500,000.00	55,500,000.00
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	0.00	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,781,067,494.73)	(1,781,067,494.73)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	0.00	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(20,147,500.00)	-	-	(20,147,500.00)
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	11,744,520,814.45	2,112,044,177.04	718,836,000.00	(190,910,142.36)	14,384,490,849.13
1	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,427,766,918.29	1,427,766,918.29
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	10,000,000.00	-	-	10,000,000.00
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	11,744,520,814.45	2,122,044,177.04	718,836,000.00	1,236,856,775.93	15,822,257,767.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн	6,060,016,175.09	14,062,506,406.49
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,766,167,789.46	10,896,571,480.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	20.00	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,533,376.00	16,733,963.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	1,968,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,291,314,989.63	1,181,200,963.49
1.2	Мөнгөн зарлагын дүн	6,360,989,130.63	10,588,432,093.75
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,368,954,715.88	3,678,673,250.99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	319,478,337.37	459,911,944.90
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	90,636,563.17	36,228,806.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	197,927,775.75	207,949,118.15
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,945,340,639.82	2,202,942,895.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	181,637.19	661,012.86
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	258,025,849.51	350,517,960.25
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	50,967,220.00	69,403,456.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,129,476,391.94	3,582,143,649.60
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(300,972,955.54)	3,474,074,312.74
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн	1,531,247.06	11,332,991.48
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	20,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	1,531,247.06	11,256,983.88
2.1.8	Бусад	0.00	56,007.60
2.2	Мөнгөн зарлагын дүн	13,001,900.00	2,362,552,067.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	846,900.00	1,640,075,400.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,155,000.00	4,775,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	717,701,667.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,470,652.94)	(2,351,219,075.52)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(312,443,608.48)	1,122,855,237.22
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	996,425,459.71	683,981,831.23
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	683,981,831.23	1,806,837,068.45

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны Гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,426,063.2	10,505,093.3	11,143,259.3	(638,166.0)	106.1
1	Цалин	2,406,445.2	4,272,022.9	3,760,245.1	511,777.8	88.0
2	НДШ=13.5%	320,221.4	576,723.1	459,823.9	116,899.2	79.7
3	Шатахуун, тос тосолгоо	1,405,229.6	1,830,923.6	1,404,124.2	426,799.4	76.7
4	Сэлбэг засвар үйлчилгээ	373,311.7	472,774.0	388,309.4	84,464.6	82.1
5	Томилолтын зардал	416,655.9	519,900.0	274,788.0	245,112.1	52.9
6	Элэгдлийн зардал	1,770,341.3	1,965,000.0	1,549,178.5	415,821.5	78.8
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардал	3,812.7	37,282.4	35,730.7	1,551.8	95.8
8	Автомашинь оношилгоо, татвар	32,975.5	27,054.7	26,911.0	143.7	99.5
9	Автомашинь даатгал	50,967.2	95,203.7	74,273.0	20,930.7	78.0
10	Хөдлөх хөрөнгөтэй холбоотой бичиг баримт	3,237.1	2,000.0	1,307.6	692.4	65.4
11	Үйлчилгээний ба гэрээт ажлын хөлс	373,305.3	282,000.0	252,911.7	29,088.3	89.7
12	Цахилгаан	83,058.6	85,139.1	91,870.6	(6,731.5)	107.9
13	Дулаан	74,375.3	81,674.9	78,090.6	3,584.3	95.6
14	Цэвэр бохир ус	15,983.4	17,610.8	17,451.6	159.2	99.1
15	Шуудан, холбоо, интернетийн зардал	8,362.5	8,491.0	9,901.1	(1,410.1)	116.6
16	Бичиг хэрэг аж ахуйн зардал	13,350.1	10,620.5	9,712.7	907.8	91.5
17	Удирдлагын зардал	1,488.0	2,460.0	2,445.0	15.0	99.4
18	Зар сурталчилгаа	261.4	2,000.0	613.6	1,386.4	30.7
19	Тээврийн зардал дотоод	18,302.6	19,200.0	17,756.0	1,444.0	92.5
20	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2,857.9	3,600.0	2,727.3	872.7	75.8
21	Үл хөдлөх хөрөнгө ба газрын татвар	8,912.7	8,912.7	8,912.7	-	100.0
22	Урсгал болон барилгын засвар	16,379.0	150,000.0	15,451.1	134,549.0	10.3
23	Аудитын зардал	10,000.0	10,000.0	10,000.0	-	100.0
24	Аж ахуйн ажлын зардал	16,228.9	24,500.0	24,150.8	349.3	98.6
25	Шинэ Хоршооны зардал		-	2,617,043.2	(2,617,043.2)	-
26	Бусад төлбөр хураамж зардал			9,530.0	(9,530.0)	-
	Үндсэн үйл ажиллагааны нийт зардал	7,426,063.2	10,505,093.3	11,143,259.3	(638,166.0)	106.1
1	Ханшийн өөрчлөлт, банкны үйлчилгээ	1,228.1	1,500.0	805.2	694.8	53.7
2	Ахмадын зардал /1.2%/	61,162.2	121,600.0	44,501.1	77,099.0	36.6
3	Ажилтан албан хаагчдын нийгмийн асуудал /тэтгэмж тусламж/	33,026.7	70,000.0	31,320.0	38,680.0	44.7
4	Малын тэжээл, бусад	75,767.8	-	-	-	-
5	Эмнэлэг, спорт, сургалт, тэмцээний зардал	459.1	69,930.0	46,282.8	23,647.2	66.2
6	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	711,907.5	-	112,966.5	(112,966.5)	-

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

7	Түрээсийн орлогын татан төвлөрүүлэлт	192,583.2	206,143.2	165,720.8	40,422.4	80.4
8	Хүү торгууль алданги			1,051.2	(1,051.2)	-
	Үйл ажиллагааны бус зардлын дүн	1,076,134.7	469,173.2	402,647.5	66,525.7	85.8
	Нийт зардлын дүн	8,502,197.8	10,974,266.5	11,545,906.9	(571,640.4)	105.2
	Нийт орлогын дүн	6,721,130.3	11,050,226.0	13,039,916.6	(1,989,690.6)	118.0
1	Үндсэн үйлдвэрлэлийн орлогын дүн	4,670,064.5	6,068,185.0	9,833,710.6	(3,765,525.6)	162.1
2	Үндсэн үйл ажиллагааны бус орлогын дүн	2,051,065.8	4,982,041.0	3,206,206.0	1,775,835.0	64.4
	Ашиг(+), алдагдал(-)	(1,781,067.5)	75,959.5	1,494,009.7	(1,418,050.2)	1,966.9

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 858.4 сая төгрөгийн 6 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Шатахууны зардлаас сэлбэгийн зардал, хүү торгууль алдангийн зардлаас хоолны зардал, автомашины даатгалын зардлаас ордны зөвшөөрлийн зардлыг ангилал зөрчиж зарцуулсан байна.	1	1,605.3					1	1,605.3				
2	Оффисын засварын 139,6 сая төгрөгийн зардлыг урсгал зардалд бүртгэж, зардлыг капиталжуулаагүй байна.	1	139,568.2					1	139,568.2				
3	Эрүүл мэнд, спорт сургалтын зардлаас интернет, ажилчдад олгох тэтгэмжийн болон үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүний урамшууллын зардлыг ангилал зөрчиж зарцуулсан байна.	1	26,829.1					1	26,829.1				
4	Бичиг хэргийн зардлаас үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүний урамшууллын зардал, Дулааны зардлаас хог тээврийн болон сансарын холбооны иридум утасны зардлыг ангилал зөрчиж зарцуулсан байна.	1	3,280.5					1	3,280.5				
5	Ахмадын тэтгэмж, хүндэтгэлийн зардлаас оффисын засварын зардал болон харуул хамгаалалтын төлбөр, хүүхдийн бэлэгт ангилал зөрчиж зарцуулсан байна.	1	47,129.6					1	47,129.6				
6	Тус байгууллага нь тогтоол шийдвэргүйгээр ЗГХЭГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 640.0 сая төгрөгийн 3 ширхэг тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөдөө давхардуулан бүртгэсэн байна.	1	640,000.0					1	640,000.0				
	Дүн	6	858,412.6					6	858,412.6				

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 49.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 17.6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 32.2 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үнэлгээний хорооны хуралд биечлэн оролцоогүй хөндлөнгийн гишүүнд 1.3 сая төгрөгийн урамшуулал олгосон.	1	1,325.0	1	1,325.0								
ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр тус байгууллагын захирал 2024/12/10-ны Б/118 тоот тушаалаар өөртөө 4.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	4,200.0	1	4,200.0								
Тус баазын захирлын 2024/12/10-ны өдрийн Б/118 тоот тушаалаар сахилгын шийтгэлтэй 4 ажилтанд 4.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.	1	4,575.0	1	4,575.0								
Тус баазын захирлын 2024/12/16-ны өдрийн Б/122 тоот тушаалаар нийтийн орон сууцанд амьдардаг 25 ажилтанд 7.5 сая төгрөгийн түлээ нүүрсний тэтгэмж олгосон.	1	7,500.0	1	7,500.0								
ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр тус баазын захирал 2024 /7/26-ны А/13 тушаалаар өөртөө гадаад албан томилолтын 3.1 сая төгрөгийн зардал гаргасан.	1	3,125.0			1	3,125.0						
Гранд дата ХХК-тай байгуулсан гэрээгээр баазын үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах маркетингийн идэвхжүүлэлт, сошиал хаягуудад зар сурталчилгаа байрлуулах, видео контент, постерийн рийл хийх зардалд нийт 22.0 сая төгрөгийн зардал гаргасан.	1	22,000.0			1	22,000.0						

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Тус баазын өмчлөлийн талбай үндсэн хөрөнгийн бүртгэлд 22,183 кв.м, Сетсскюрвэй ХХК-р хийлгэсэн кадастрын зурагт 22,205 кв.м хэмжээтэй байгаа нь бүртгэлийн хэмжээнээс 22 кв.м-ээр зөрүүтэй байна.	1	-			1	-						
Төв аймагт байрлалтай сургалтын зориулалттай 3 га талбайтай, 15 жилийн хугацаатай эзэмших эрхийн гэрчилгээ бүхий газрыг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй.	1	-			1	-						
Өмнөх оны аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, ЗГХЭГ-ын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдэд сэлбэг, шатахууны зардалд 7.1 сая төгрөг зарцуулж, зөрчлийг давтан гаргасан.	1	7,086.8			1	7,086.8						
Худалдан авах ажиллагааны 11 тендер сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурлын баримт бичигт гишүүд ашиг сонирхлын мэдүүлгийг тухай бүрт гаргаагүй, 1 удаа гаргасан ашиг сонирхлын мэдүүлэг нь иж бүрэн бөглөгдөөгүй шаардлага хангахгүй байна.	1	-					1	-				
Тус баазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эзэмшил газарт 2 давхар 18 айлын хувьчлагдсан орон сууц байрлаж байгаа нь газраа алдах эрсдэлтэй байна.	1	-					1	-				
Хөрөнгө оруулалтын нэмэлт төсвийг 2024 оны 11 сард батлуулж, автомашин худалдан авах болон засварын зардлын тендер шалгаруулалтыг 2024 оны 10, 12 сард зохион байгуулсан.	1	-					1	-				
Тус баазын үйлчилгээнд явж буй 32 тээврийн хэрэгсэл нь улсын бүртгэлийн дугаарыг бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий болгож солиогүй байна.	1	-					1	-				
Дүн	13	49,811.8	4	17,600.0	5	32,211.8	4	-	0	-	0	-

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 78,836.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
мянган төгрөгөөр/								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тус бааз нь Улсын төсөвт үйлдвэрийн газар байх үед мөрдөж байсан 2022 онд батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам", 2019 онд батлагдсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам", "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлаагүй, тус байгууллагын өмчийн хэлбэр өөрчлөгдсөн байхад эдгээр журмуудыг үйл ажиллагаандаа одоог хүртэл мөрдөж байна.	1	-					1	-
ТӨБЗГ-ын 2024 оны 7-р сарын 4-ны 352 тоот тогтоолоор Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-н захирлыг томилсон тухай нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй байна.	1	-					1	-
Ахмадын тэтгэмж, хүндэтгэлийн зардал батлуулсан боловч ахмадын сангийн данс нээлгээгүй байна.	1	-					1	-
Дүн	3						3	
Нийт дүн	3	-					3	-